



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Ж.БАТСУУРЬ ТАНАА

МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот  
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуулийн гудамж 11,  
Утас: 264216, Факс: 264460

2015. 03. 12 № 394

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Г

Тогтоол, дүгнэлт, зөвлөмж  
хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар танай аймаг дахь Салбар зөвлөлийн даргын сонсголыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэллэлцэж гаргасан тогтоол, дүгнэлт, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.


Төрийн албаны зөвлөлийн тогтоол, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд тайлагнахад хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авна уу.

Хавсралт 3 хуудастай.

Хуулбарыг: Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ц.Лхамсүрэнд.

ДАРГА

Б.ЦОГОО



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛД**

**ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

*Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах,  
Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай*

2015.03.12.

Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ц.Лхамсүрэнгийн сонсголыг авч хэлэлцээд дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Нэг.** Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн чиг үүргээ хэрэгжүүлэх 100 хувийн чадамжтай байна.

**Хоёр.** Тус Салбар зөвлөл Салбар зөвлөлийн гишүүний ажил үүргийн хуваарь (аймгийн ЗДТГ-ын Хуулийн хэлтсийн дарга)-т аймаг, сумдын Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын гаргасан хүний нөөцийн холбогдолтой шийдвэрүүдэд хяналт тавих зохистой механизм бүрдүүлэн ажиллаж байна.

**Гурав.** Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж албан хаагчийг шинээр ажилд авахад болон албан тушаалын ангилал зэрэглэл ахих, өөр ажил албан тушаалд шилжихэд тухайн шинэ орчин нөхцөлд шаардагдах мэдлэг, дадлага, арга барил эзэмшүүлэх зорилгоор байгууллагын ахмад ажилтнаар ахлуулсан 3-5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй баг гарган ажиллаж, тэдгээр хүмүүст 1-3 долоо хоногийн зорилтот сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж байгаа нь сайшаалтай байна.

**Дөрөв.** Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөл чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч дотоод ажил, хугацаатай өгсөн үүрэг, ажлынхаа тайлагналтад онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

**Тав.** Салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө дараах асуудлыг тусган ажиллах, хэрэгжилтийг хангахад онцгой анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- 1) Төрийн албаны үйл ажиллагааг иргэдээд нээлттэй ил тод мэдээлэх (цахим хуудсанд байршуулах),
- 2) Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн тухайн оны хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг өгсөн чиглэлийн дагуу боловсруулалт хийж баримтжуулан, холбогдох нотолгоог хавсарган цаг хугацаанд нь ирүүлж байх,
- 3) Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх,
- 4) Нөөцийн судалгааг тухай бүр хийж байх,
- 5) Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг аймгийн нутаг дэвсгэр дээр төрийн байгууллага /таануул, цэргийн анги хамаарахгүй/ бүрээс авч Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь мэдээлэх.

**Зургаа.** Төрийн алба, төрийн албан хаагчийн харилцааны талаар хууль тогтоомж зөрчсөн өргөдөл, гомдолыг хүлээн авч хуулийн хүрээнд түргэн шуурхай шийдвэрлэх, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл, тайлбарыг Төрийн албаны зөвлөл болон гомдол, маргаан гаргагч нарт шуурхай мэдээлдэг байх.

**Долоо.** Салбар зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг 2012 онд 150 онооны 15 үзүүлэлтээр дүгнэхэд аймаг, нийслэл(22)-ээс Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөл 104.0 онооны үзүүлэлт (69.33 хувьтай)-ээр 20 дугаарт; 2013 онд 200 онооны 20 үзүүлэлтээр дүгнэхэд аймаг, нийслэлээс Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөл 99.5 онооны үзүүлэлт (49.75 хувь)-ээр 19 дүгээрт; 2014 онд 210 онооны 21 үзүүлэлтээр дүгнэхэд аймаг, нийслэлээс 119.5 оноо буюу 56,9 хувь (19 дүгээрт жагсан)-ийн хэрэгжилттэй байгаад дүгнэлт хийж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

**Найм.** Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 40-д заасныг чанд баримтлаж ажиллах.

**Ec.** Төрийн жинхэнэ албанц анх орох иргэний мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүн мэдээ, холбогдох бичиг баримтыг Төрийн албаны зөвлөлд шаардлага хангулан ирүүлэх.

#### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ